

## ОРОСООС БУСАД СЛАВ ХЭЛТЭН УЛСУУДЫН УРАН ЗОХИОЛ МОНГОЛД

Д. Энхжаргал<sup>59</sup>

**Resume:** *In this research paper we have discussed translated works from slavonic languages into Mongolian except Russian and given the research-based information. Translated literature from slavonic languages into Mongolian were found in the libraries, namely: The National Library of Mongolia, Ulaanbaatar Public Library of Natsagdorj. Dand the Library of National University of Mongolia. The overview of the translated works was done. The paper has following parts: An introduction, Belorussian literature, Bulgarian literature, Polish literature, Slovak literature, Ukrainian literature, Czech literature and the Conclusion.*

**Түлхүүр үгс:** *Белорусс, Болгар, Словак, Польш, Украин, Чех, уран зохиол, орчуулга*

### Оршил

Энэхүү өгүүлэл Монгол улсын төв номын сан, Нацагдоржийн нэрэмжит Нийтийн номын сан, МУИС-ийн номын сангуудад түшиглэн оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиол Монгол улсад хэрхэн дэлгэрснийг тогтоох, орчуулагчдын судалгааг хийх, мөн түүнчлэн орчуулагдсан бүтээлийн тоймыг гаргах зорилготой. Слав олон хэл гарвалзүйн хувьд Энэтхэг-Европын хэлний бүлд багтдаг. Энэ бүлийн Слав хэлний дэд бүлэгт орос, украин, белорусс (зүүн слав), словен, серб-хорват, македон, болгар (өмнөд слав), чех, словак, польш (баруун слав) хэлнүүд хамаарна. Бид энд буй хэлнүүдээс орос хэлийг авч үзээгүй. Украин, белорусс, болгар, чех, словак, польш зэрэг зургаан улсын уран зохиол Монголд орчуулагдаж, нийтийн хүртээл болсон тухай өгүүлэх болно. Бусад улсуудын уран зохиол Монголд төдийлөн дэлгэрээгүй байна.

### 1. Белоруссын уран зохиол Монголд

Белоруссын утга зохиолоос анх 1957 онд орос хэлнээс “Хөнгөн ажил” нэртэй, Белорусс ардын үлгэрийг Б.Лувсан орчуулж, “Пионерийн үнэн” сонины 8-р сарын 6-ны дугаарт нийтлүүлж байжээ. Үүний дараагаар 1959 онд Я.Коласын “Хавар” хүүхдийн шүлэг, Мавр Ливкогийн “Модон халбага” өгүүллэг, 1966 онд Белоруссын цоморлиг, “Үерийн дохио”, 1984 онд “Белоруссын зохиолчдын өгүүллэг”, 1987 онд П.Бровкагийн “Үүлс: шүлэг”, Н.Гилевичийн “Домогт партизануудын алдрын өлгий: шүлэг”, 1988 онд П.Бровкагийн Марат Казей: Найраглал, И.Шамякины “Итгэлээр амилсан

---

<sup>59</sup> МУИС, ШУС, ХУС-ын Европ судлалын тэнхимийн эрхлэгч, доктор /Ph.D/

зүрх”зэрэг нийт 11 бүтээл хэвлэгджээ. Хэмжээний хувьд И.Мележийн “Намагт нутгийнхан”, “Үерийн дохио”, И.Шамякины “Итгэлээр амилсан зүрх” зэрэг нь нилээд зузаан романууд байна. Орчуулагчдын хувьд дагнасан байдал ажиглагдахгүй байна. Үлгэр-1, шүлэг-3, өгүүллэг-1, цоморлиг-1, роман-3, найраглал-1 байна. Белоруссын уран зохиолыг монголчууд орос хэлнээс голлонорчуулжээ. Зохиолын сэдвийн хувьд хүний амьдрал, хувьсгалын үйл хэрэг, сайхан сэтгэл, сургамж гэх мэт байна.

Хүснэгт №1

№	Зохиолч, зохиолын нэр	Орчуулагч, хэвлэлийн газар, хэвлэсэн он	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан
1	Белоруссын цоморлиг	Д.Гомбожав, З.Сандагаа, Ц.Цэдэнжав, УХХЭХ, 1966	тодорхойгүй.
2	Белоруссын зохиолчдын өгүүллэг	Г.Амар, УБ, УХГ, 1984	тодорхойгүй.
3	Бровка П. Үүлс:шүлэг	С.Баясгалан //Октябрийн гэрэл, 1987	орос хэлнээс
4	Бровка П. Марат Казей: Найраглал	Ч.Лхагва, УБ, АБЯ, 1988	орос хэлнээс
5	Гилевич Н. Домогт партизануудын алдрын өлгий: шүлэг	Х Мэргэн. //Октябрийн гэрэл, 1987	орос хэлнээс
6	Колас Я. Хавар, Хүүхдийн шүлэг	Г.Дамдин, УБ, 1959	орос хэлнээс
7	Мавр Ливко“Модон халбага” өгүүллэг”	“Соёл утга зохиол” 1959, 1-р сарын 1	орос хэлнээс
8	Мележ.И “Намагт нутгийнхан	Ш.Очирбат, УБ, УХГ, 1978	орос хэлнээс
9	Мележ.И“Үерийн дохио”	Ш.Очирбат, УБ, УХГ, 1978	орос хэлнээс
10	“Хөнгөн ажил”, Белорусс ардын үлгэр	Б.Лувсан, Пионерийн үнэн, 1957, 8-р сарын 6	орос хэлнээс
11	Шамякин.И “Итгэлээр амилсан зүрх”	Ё.Шийхар, УХГ, 1988	орос хэлнээс

## 2.Болгарын уран зохиол Монголд

Болгарын уран зохиолоос хамгийн анх монгол хэлнээ 1953 онд “Болгарын үгүүлэл найраглалууд” нэртэй номыг Дашдорж орчуулан хэвлүүлжээ. Болгарын уран зохиолоос нийтдээ 100 гаруй зохиолчийн 300 орчим бүтээл болгар, орос, герман хэлнээс орчуулагдаж, нийтийн хүртээл болсон байна. Болгар хэлнээс монгол хэлэнд орчуулж байсан орчуулагчид нь А.Самбалхүндэв, Н.Лхагва, Г.Донид, Б.Жамъянбаатар нар бөгөөд нийтдээ 50 орчим бүтээлийг эх хэлнээс нь монгол хэлэнд буулгажээ. Орчуулагч А.Самбалхүндэв Д.Овадиягийн “Комиссарын тухай дурсамж”, “Партизаныуд-Хурим”, “Уулзалт” зэрэг яруу найргийн бүтээлүүдийг, орчуулагч Н.Лхагва П.Лазаровын “Дархан аварга” (1974), мөн Г.Донидын хамт Л.Левчевийн “Мөнхийн дуулал”, (40 гаруй яруу найраг, 1986), Б.Жамъянбаатар “Улаан сарнай” (1974), Караславов.Г “Ном амссан хулганууд” (1977), Е.Станевын “Намуун орой” (1980) зэрэг бүтээлүүдийг болгар хэлнээс монгол хэлнээ хөрвүүлжээ.

2005 онд Болгарын яруу найрагчдын бүтээлийн цомог “Цэнхэр Пиринийн дуулал” нэртэйгээр Улаанбаатар хотноо хэвлэгдсэн бөгөөд өмнө нь орчуулагдаж байсан 73 зохиолчийн 220 орчим шүлэг, яруу найраг оржээ. 1953-2015 он хүртэлх хугацаанд монголчууд Болгарын 230 орчим яруу найргийн бүтээлийг орчуулсан байна. 1950-1960 онд 25 бүтээл, 1960-1970 онд 11, 1970-1980 онд 9, 1980-1990 онд 48, 1990 оноос хойш 10 бүтээл, тэр дунд 220 гаруй яруу найргийн бүтээл бүхий “Цэнхэр Пиринийн дуулал” багтана. Хүснэгт №2-т болгарын уран зохиолоос монгол хэлнээ орчуулагдсан бүтээлийн тоймыг үзүүлэв.

Хүснэгт №2

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар хэвлэсэн он	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан
1	Болгарын үгүүлэл найраглалууд	Дашдорж, УХҮ, УБ, 1953	тодорхойгүй
2	Стефанова Лиляна “Родопын уулс сүндэрлэж байна”	Ч.Лхамсүрэн, Г.Дамдин УБ, УХГ, 1955,	орос хэлнээс
3	“Танхил хүүхэн”, УБ, УХГ,	Г.Дамдин, УБ, 1956,	тодорхойгүй
4	Ботев Х. Хагацан салахад, шүлэг	С.Доржпалам, “Цог”, 1956, №4, 65-66-р талд	тодорхойгүй
5	Вазов И. Ажиллацгаая-Эхдээ	Д.Чимиддорж, “Утга зохиол”, 1956 оны 9 сарын 15	тодорхойгүй

6	Вапцаров Н. Шүлгүүд	Хэн орчуулсан нь тодорхойгүй, УБ,УХГ, 1956	тодорхойгүй
7	Радев Р. Хүний хүсэл зоригоор (найруулал)	Хөдөлмөр, 1956, 9-р сарын 15	тодорхойгүй
8	Анчин хүү-Гал халуун дурлал, Болгар ардын аман зохиолоос	Б.Энэбиш, Утга зохиол, 1957, 9 сарын 15	орос хэлнээс
9	“Залхуу охин” Болгар ардын үлгэр	Д.Содномдаржаа, //Таван хархүү” ном, 1957, 6-8-р тал	орос хэлнээс
10	Мэхтэй хүү- Их зантай хүн, Болгар ардын шог ярианаас	Г.Амар, “Соёл утга зохиол”, 1958, 9-р сарын 3	орос хэлнээс
11	Методиев Дмитрий. Эхнэртээ (Шүлэг), орчуулсан	Б.Энэбиш, “Утга зохиол, 1957, 9-р сарын 15	орос хэлнээс
12	Орлинов О. Болгар эр, (Шүлэг),	Б.Энэбиш, “Утга зохиол, 1957, 7-р сарын 15	орос хэлнээс
13	Овадия Д. Комиссарын тухай дурсамж (Шүлэг)	А.Самбалхүндэв, “Утга зохиол, 1957, 11-р сарын 20	болгар хэлнээс
14	Овадия Д. Партизанууд-Хурим (Шүлэг)	А.Самбалхүндэв, Үнэн, 1957, 10-р сарын 12	болгар хэлнээс
15	Овадия Д. Уулзалт (Партизаны тухай шүлгээс)	А.Самбалхүндэв, “Утга зохиол, 1957, 11-р сарын 7	болгар хэлнээс
16	Овадия Д. Хүү (Шүлэг)	А.Самбалхүндэв, “Соёл утга зохиол”, 1958 оны 7 сарын 2	болгар хэлнээс
17	Ван Босилек О. Ухаантай тариачин (Болгар ардын үлгэр)	А.Самбалхүндэв, “Соёл утга зохиол”, 1958, 9-р сарын 17	орос хэлнээс
18	Вапцаров Н. Ботев, шүлэг	Л.Түдэв, Соёл утга зохиол, 1959, 12-р сарын 3	орос хэлнээс
19	Вазов И. Амьд түүх, шүлэг	Соёл утга зохиол, 1959, 9-р сарын 10	тодорхойгүй

20	Вазов И. Амьд түүх, шүлэг	Сталинч, 1960, 10-р сарын 15	тодорхойгүй
21	Ботев Х. Цэрэг эрчүүл, шүлэг	Ш.Цэндгомбо, “Соёл утга зохиол”, 1960 оны 9-р сарын 9	тодорхойгүй
22	Ботев Х. “Гайдукууд”, шүлгүүд	орчуулагч Ц.Цэдэнжав, УБ, УХГ 1964	тодорхойгүй
23	Баланов П. Торойнууд, хошин өгүүллэг	орч. Ч.Мөнхбаяр//Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй
24	“Баян ядуу хоёр” болгар ардын үлгэр	М.Бадарч, Алтан алим үлгэрүүд, 2005	герман хэлнээс
25	Вазов И “Талхинд”	Ш.Доржготов, УБ, УХГ, 1976	орос хэлнээс
26	Вешим М. Саятны төлөөх ангуучлал	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй
27	Винаров И. Нууц фронтын дайчид: Баримтат эсээ	Д.Дашдаваа	орос хэлнээс
28	Влайков Тодор. Славчо өвгөний ач охин	Ц.Шагдар, Соёл утга зохиол, 1960 оны 10 сарын 15	орос хэлнээс
29	Вежинов П. “ <u>Мөр үлдсэн нь</u> ”	Г.Дамдин, УБ УХГ 1958	орос хэлнээс
30	Вежинов П. “Хэмжигдэхүүн” орч.	Ц.Шарав, // Оготор шар байшин, УБ, 1984	тодорхойгүй
31	Гуляшки А. “Гэрэлт зам”	Д.Самдан, УБ, УХГ 1966	орос хэлнээс
32	Димов Д. “Тамхи”	Ш.Доржготов, УБ, УХГ, 1967	орос хэлнээс
33	Димов Д. “Тамхи”, дэд дэвтэр	Ш.Доржготов, УБ, УХГ, 1971,	орос хэлнээс
34	Калчев К. Дахиад бас таван сар болж, дахиад бас цэцэг дэлгэрнэ:	Г.Хадбаатар //Оготор шар нар, УБ, 1984	тодорхойгүй

35	<u>Караславов Г. “Ном амссан хулганууд”</u>	Б.Жамъянбаатар, УБ АБЯ-ны хэвлэл 1977	болгар хэлнээс
36	Ламар. 9-р сарын 9, шүлэг,	Сталинч, 1960, 10-р сарын 15	тодорхойгүй
37	<u>Лазаров П. “Дархан аварга”</u>	Н.Лхагва, УБ, УХГ, 1974	болгар хэлнээс
38	Левчев Л “Мөнхийн дуулал” яруу найргийн цоморлиг	Г.Донид, Н. Лхагва, УБ, УХГ, 1986	болгар хэлнээс
39	Льочев П. Сугарын дун: Зөгнөлт өгүүллэг	Ц.Хатантөмөр, УБ, 1989	тодорхойгүй
40	Минков С. “Сүрлэн дарга”	Г.Амар, УБ, УХГ, 1959	тодорхойгүй
41	Мишев Г. “Зуслангийн дэнж”, тууж	Ц.Шарав//Оготор шар нар, УБ, 1984	тодорхойгүй
42	Младен Исаев “Оргилд хүрэх зам” Шүлэг	М.Ширчинсүрэн, Соёл утга зохиол, 1960, 4-р сарын 21	тодорхойгүй
43	<u>Мөнхийн дууны домог</u>	УБ, УХГ, 1973, тодорхойгүй.	тодорхойгүй
44	Наковский А “ <u>Залуу нас осолдуузай</u> ”	М.Дэчин, УБ, УХХЭХ 1968	тодорхойгүй
45	Пеев Д. “Болор аяганы нууц” өгүүллэг	Пунцаг, 1991	тодорхойгүй
46	Пеев Д. “Болор аяганы нууц”	Ц.Цэрэн, УБ, УХГ, 1992	тодорхойгүй
47	Пелин Е. Ян Бибиянд тохиолдсон ер бусын явдал	Н.Намжилдорж УБ, 1966,	тодорхойгүй
48	Пелин Е. Ян Бибиян саранд аялсан нь	Ц.Сандаг, УБ, 1976	тодорхойгүй
49	Петров Ивайло “ Нонагийн дурлал”	Д.Цэрэндаш, УБ, УХХЭХ, 1966	орос хэлнээс
50	Пушков И. Хамгийн сайхан цэцэг (найруулал)	“Залуучуудын үнэн”, 1958, 7 сарын 2	тодорхойгүй

51	Радевский Х. Гомдол эрсэн гахай (Шүлэг)	С.Жамбалдорж, “Матар” 1959 №10	орос хэлнээс
52	Стефанова Лиляна Тэр бид хоёр (Шүлэг)	Цэдэнжав“Соёл утга зохиол”,1958, 5-р сарын 6	тодорхойгүй
53	Станев Е.” Намуун орой”,	Б.Жамъянбаатар, УБ, УХГ, 1980	болгар хэлнээс
54	Станев Е “Иван Кондарев”, тэргүүн дэвтэр	Ш.Доржготов, УБ, УХГ 1982	орос хэлнээс
55	Станев Е.Иван Кондарев, дэд дэвтэр	Ш.Доржготов, Д. Самдан, УБ, УХГ, 1984	орос хэлнээс
56	Станев Э. “Цасан гэр”	Л.Далхсүрэн, УБ, УХГ, 1970,	тодорхойгүй
57	Станев Е. Дорго: тууж	Ч.Лхагва, //Оготор шар нар, УБ, 1984	тодорхойгүй
58	“Тангараг”, Болгарын зохиолчдын шүлэг, өгүүллэгийн эмхтгэл	Ш.Доржготов, Л. Түдэв гэх мэт олон орчуулагч. УБ, 1970	тодорхойгүй
59	Туманов В. Уран бүтээлийн зовлон: хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй
60	Улаан сарнай, УБ, УХГ, 1974	Б.Жамъянбаатар	болгар хэлнээс
61	Цэнхэр Пиринийн дуулал, Болгарын яруу найрагчдын бүтээлийн цомог, 73 зохиолчийн 220 орчим шүлэг, яруу найраг	Олон орчуулагчтай, УБ, 2005	болгар, орос
62	Хайтов Н. “Край буюу гэрлэхийн учир”	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй
63	Цонев К. Нэн сонирхолтой ном, хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр//Инээхүйн гайхамшиг, 2004	тодорхойгүй

Монгол хэлнээ орчуулагдсан Болгарын уран зохиолын сэдэв нь залуу нас, хайр сэтгэл, ажил хөдөлмөр, эх орон, хувьсгал, дэлхийн дайн, байгаль дэлхий, шог хошин, уран зөгнөл гэх мэт өргөн хүрээг хамарчээ.

### 3.Польшийн уран зохиол Монголд

Польш хэлнээс анхлан монгол хэлэнд 1955 онд нэрт дуун хөрвүүлэгч, зууны манлай эрдэмтэн Б.Ринчен “Адам Мицкевич” гэсэн номыг хөрвүүлжээ. Польшийн уран зохиолыг монголчууд польш, орос, эсперанто, солонгос хэлнээс орчуулсан байна. Б.Ринчен польш хэлнээс “Гурван алим (УБ, 1966), “Солонго” (1970), “Чандруу Алмас хоёр” (1978) зэрэг бүтээлүүдийг, Д.Ким “Хамгаас хөөрхөн” (1967), “За одоо ууцгаая” (1990), “Өглөөгүүр шуурга өнгөрлөө” (1989) зэргийг, Р.Санжаасүрэн “Эрхэм Жонс та хүн мөн үү?” (1967), С.Аюуш “Осол” (1983) бүтээлүүдийг польш хэлнээс монгол хэлэнд орчуулсан байна. Орчуулагч Ч.Догсүрэн П.Болеславын “Фараон” романыг 1981, 1983 онд эсперанто хэлнээс орчуулан гаргажээ. Х.Сенкевичийн “Күо Вадис” (2010) романыг М.Амартайван солонгос хэлнээс орчуулсан байна. 1955-2015 оны хугацаанд польшийн уран зохиолоос 40 орчим бүтээлийг монгол хэлнээ хөрвүүлэн нийтийн хүртээл болгосон ажээ. 1953-1960 онд 12, 1961-1970 онд 6, 1971-1980 онд 8, 1981-1990 онд 6, 1990-2000 онд огт орчуулаагүй. 2004 оноос өнөөг хүртэл 5 орчуулгын бүтээл тус тус хэвлэгджээ.

#### Хүснэгт№3

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар хэвлэсэн он,	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан
1	Адам Мицкевич	Б.Ринчен, УБ, УХГ, 1955	польш хэлнээс
2	Андшеевский И. “Чандруу Алмас хоёр”	Б.Ринчен, УБ, УХГ, 1978	польш хэлнээс
3	Анитц Б. “Араатны дунд гар хоосон”	УБ, 1972	тодорхойгүй
4	Билински В. “Осол”	С.Аюуш, УБ, УХГ, 1983,	польш хэлнээс
5	Болеслав П. “Фараон”	Ч.Догсүрэн, УБ, УХГ, 1981, 1983	эсперанто хэлнээс
6	Болеслав П. “Фараон”	Ч.Догсүрэн, УБ, УХГ, 1983	эсперанто хэлнээс



7	Броневский Б. “Шүлгүүд”	Ц.Цэдэнжав, УБ, УХҮ, 1953	орос хэлнээс
8	Броневская Я.” Суманд сөгдөөгүй хүний тухай”	Ж.Аминдаваа, УБ, УХХЭХ, 1955,	орос хэлнээс
9	Болжморын шаахай, Польш ардын үлгэр	Д.Содномдаржаа, Таван хархүү ном, 1957	орос хэлнээс
10	Ванда Василевска “Солонго”	Б.Ринчен, УБ, УХГ, 1970	польш хэлнээс
11	Галчинский К. И. Чөлөөт Варшав (шүлэг)	Г.Дамдин, Соёл, утга зохиол, 1959, 10-р сарын 23	орос хэлнээс
12	Генрих Сенкевич “Гурван хүүхдийн хувь заяа”	З.Саарал,УБ, УХГ, 1968	тодорхойгүй
13	Гисгес Ян Марина. Улаанбаатар дээрх саран (шүлэг)	Хэн орчуулсан нь тодорхойгүй. Үнэн, 1960, 5-р сарын 15	тодорхойгүй
14	Гурван алим	Б.Ринчен, УБ, УХГ, 1966	польш хэлнээс
15	Сат-ок “Нууц мөрөөр”	Д.Догсомжав, УБ, Мөнхийн үсэг, 2006	тодорхойгүй
16	Сат-Ок “Давст хадны хөндий”	Д.Догсомжав, УБ, Мөнхийн үсэг, 2006	тодорхойгүй
17	Домбровска М. “За одоо ууцгаая”	Д. Ким, УБ, УХГ, 1990	польш хэлнээс
18	Кертиес И.”Хүн заяа ноогдоогүй нь”	Г.Бошигт, 2005, УБ, УХГ	тодорхойгүй
19	Корчак Я. “Эргээд хүүхэд болсон чинь”,	С.Галсан, УБ, АБЯ, 1976,	тодорхойгүй
20	Котович В. “Фронтын зам”	С.Аюуш, УБ, УХГ, 1980,	тодорхойгүй

21	Лем С. “Эрхэм Жонс та хүн мөн үү?”	Р.Санжаасүрэн, УБ, УХГ, 1967	польш хэлнээс
22	Маринович А. “Тодорхойлолт гурван шүлэг”	Л.Отгон, “Матар” 1960 №10	орос хэлнээс
23	Махеек В. “Өглөөгүүр шуурга өнгөрлөө”	Д.Ким, УБ, УХГ, 1989	польш хэлнээс
24	Мокрский Я. Үнэн юм биш байгаа: Хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр, Инээхүйн гайхамшиг, УБ, 2004	тодорхойгүй
25	Наранцэцэг: польш шүлэг, өгүүллэгийн түүвэр	Л.Дашням, УБ, УХГ, 1974	польш хэлнээс
26	Овсяный Г. “Дайн үүссэн нууц”	Хэн орчуулсан нь тодорхойгүй, 1974 он	польш хэлнээс
27	Остроменский. Б. Захидал-Шаахай (шүлгүүд)	Ш.Цэндгомбо, Соёл утга зохиол, 1958, 11-р сарын 19	орос хэлнээс
28	Тариачны өргөдөл, Польш ардын үлгэр	Д.Содномдаржаа, Таван хархүү ном, 1957	орос хэлнээс
29	Тувим Ю. Жийв жийв (шүлгүүд),	С.Бадраа, УБ, 1956	орос хэлнээс
30	Ружевич Т. Хүсэл, Тадеуш Боровскийн дурсгалд, (шүлэг)	Хэн орчуулсан нь тодорхойгүй. Утга зохиол, 1957, 4-р сарын 17	орос хэлнээс
31	Сенкевич Х. “Күо Вадис”	М.Амартайван, УБ, Мөнхийн үсэг, 2010	солонгос хэлнээс
32	Фидлер А. Бяцхан Бизон	Б.Чимид-Очир, УБ, АБЯ, 1970	тодорхойгүй.
33	Шельбур-Зарембина Э. “Хамгаас хөөрхөн”	УБ, Д.Ким, 1967	польш хэлнээс
34	Шмаглевска С.	Ц.Шүгэр, УБ, УХГ,	орос хэлнээс

	“Биркенаугийн утаа”	1975	
35	Юлиан К. Сорви, өгүүллэг	Б.Сүрэн, Залгамжлагч, 1960 №6	орос хэлнээс
36	Янчарский Ч. Дэлдэн бамбаруушийн хөгтэй явдал	Хэн орчуулсан нь тодорхойгүй. УБ, УХГ, 1978	тодорхойгүй.

Монгол хэлнээ орчуулагдсан Польшийн уран зохиолын гол сэдэв нь Фашизмын эсрэг Польшийн ард түмний хийсэн тэмцэл, Дэлхийн I, II дайн, эх орноо хамгаалах үзэл, уран зөгнөл, хөгтэй явдал, түүх домог зэрэг байна.

#### 4. Словакийн уран зохиол Монголд

Чехословак улс 1955 онд Монгол улстай дипломат харилцаа тогтооход Чех, Словак хоёр хамтдаа холбооны бүтэцтэй улс байсан тул ихэнх тохиолдолд чех, словак уран зохиолыг ялгалгүй хамтад нь орчуулж байсан. Гэхдээ Монголд хэвлэгдсэн Словакийн уран зохиол Чехийн уран зохиолыг бодвол тооны хувьд цөөн байдаг. Анхны словак зохиолууд нэрт орчуулагч Д.Алтангэрэлийн чех болон словак хэлнээс орчуулсан “Тэнгэрийн элч”, УБ, 1970 бүтээлд анхлан хэвлэгдсэн. Үүний дараагаар Д.Алтангэрэл “Төөрөлдсөн хүнтэй уулзсан нь”, “Учрал” (Чех, Словакийн зохиолчдын өгүүллэг, УБ, УХГ, 1987) зэргийг орчуулан гаргасан. 1985 онд Ц.Цэрэн Я.Есенскийн “Братиславын булшнаа”, 1987 онд орчуулагч Д.Алтанхуяг В.Завадагийн “Алдар нэрийг би горилохгүй”, Я.Кострагийн “Братиславын хавар” (Утга зохиол, урлаг №19) зэргийг орчуулан нийтлүүлжээ. Словак хэлнээс уран зохиолыг голчлон орчуулсан хүн бол Д.Алтангэрэл болно.

Хүснэгт №4

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар хэвлэсэн он,	Монгол хэл рүү орчуулсан хэл
1	Есенский Я. “Братиславын булшнаа”	Утга зохиол, урлаг №19, 1985, орч. Ц.Цэрэн	тодорхойгүй.
2	Завада В. “Алдар нэрийг би горилохгүй”	Д.Алтанхуяг, 1987 (Утга зохиол, урлаг №19)	тодорхойгүй
3	Клара Я. “Төөрөлдсөн хүнтэй уулзсан нь”	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1986	словак хэлнээс

4	Костра Я. “Братиславын хавар”	Утга зохиол, урлаг №19	тодорхойгүй.
5	Учрал” Чех, Словакийн зохиолчдын өгүүллэг	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1987	чех болон словак хэлнээс
6	“Тэнгэрийн элч”	Д.Алтангэрэл, УБ, 1970	чех болон словак хэлнээс

Монгол хэлнээ орчуулагдсан Словакийн уран зохиолын сэдэв нь Дэлхийн I, II дайн, дайны үеийн баатрууд, эх орныхоо төлөө тэмцсэн ард түмний тэмцэл гэх зэрэг байна.

### 5.Украины уран зохиол Монголд

Украины уран зохиолоос хамгийн анх 1956 онд украины зохиолч О.Кравецкийн Ханьпугийн охин, зохиолыг Шаравжамц орчуулжээ. Үүнээс хойш Д.Гомбожав Т.Г.Шевченкогийн “Зарц бүсгүй” (УБ, 1964), Д.Дашдаваа М.В.Гаршины “Дөрвөн хоног” (УБ, 1965), 1968 онд М.Дарамваанчиг М.Стельмахын ”Хүний цус ус биш” зохиолыг, Д.Чойжил Ю.Дольд Михайликийн “Ганц дайчин ганцаардахгүй” (УБ, 1969), Л.Түдэв М.Стельмахын “Хун цэнгийн цуваа” (УБ, 1970), Ч.Лхагваа, Ю.Яновскийн “Морьтон” (УБ, 1972), Г.Амар О.Гончарын “Хонх” (УБ, УХГ, 1976), Д.Алтангэрэл Р.Кочарын “Хүү эргэж ирлээ” (1986), Б.Энэбиш В.Сосюрагийн “Украин минь” (УБ, 1987), С.Баясгалан Н.Бажаны “Намрын хөгжим” (УБ, 1987), Д.Баасанжав В.Орлёнкогийн “Буун дуугүй операц” (УБ, 1989) гэх зэрэг бүтээлүүдийг орос хэлнээс орчуулж, нийтийн хүртээл болгосон байна. Украины уран зохиолоос нийтдээ 20 орчим бүтээл монгол хэлэнд орчуулагдсан байна. Эдгээрээс хамгийн алдартай нь Ю.Дольд Михайликийн “Ганц дайчин ганцаардахгүй” зохиол болно.

#### Хүснэгт №5

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар, хэвлэсэн он	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан
1	Бажан Н. “Намрын хөгжим”, шүлэг	С.Баясгалан, УБ, 1987	орос хэлнээс
2	Гаршин М. В. “ Дөрвөн хоног”	Д.Дашдаваа, УБ, УХХЭХ, 1965	тодорхойгүй.
3	Гончар О. “Хонх”	Г.Амар, УБ, УХГ, 1976	орос хэлнээс
4	Дольд Михайлик Ю. “Ганц дайчин	Д.Чойжил, УБ, УХГ, 1969	орос хэлнээс

	ганцаардахгүй”		
5	Жванецкий М. “Мэс засалч”, Хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, УБ, 2004	тодорхойгүй.
6	Жванецкий М. “Шлягер” Флюгерийн эсрэг, хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр //Инээхүйнгайхамшиг, УБ, 2004	тодорхойгүй.
7	Кочар Р. “Хүү эргэж ирлээ” өгүүллэг	Д.Алтангэрэл //Мөнхийн дурсгал, 1986	орос хэлнээс
8	Кравець О. Ханьпугийн охин	Шаравжамц, УБ, УХГ, 1956	тодорхойгүй.
9	Макивчук Ф. “Оносон нэрд би дуртай”, Хошин өгүүллэг	Ч.Мөнхбаяр //Инээхүйн гайхамшиг, УБ, 2004	тодорхойгүй.
10	Орлёнок В. “Буун дуугүй операц”	Д.Баасанжав, УБ, УХГ, 1989	тодорхойгүй.
11	Руденко Б. “Бурхан нуур” уран зөгнөлт өгүүллэг	Пүрэвдагва // уран зөгнөлт тууж өгүүллэгүүд, УБ, 1984	тодорхойгүй.
12	Сосюра В. “Украин минь”, шүлэг	Б.Энэбиш, Октябрийн гэрэл, УБ, 1987	тодорхойгүй.
13	Стельмах М. “Хун цэнгийн цуваа”	Л.Түдэв, УБ, АБЯ, 1970	тодорхойгүй.
14	Стельмах М.”Хүний цус ус биш”	М.Дарамваанчиг, УБ, 1968	орос хэлнээс
15	Украинка Л. “Тариан түрүүхэн”	Ц.Шагдар, УБ, 2011, Содпресс	орос хэлнээс
16	ШевченкоТ.Г.“Зарц бүсгүй”	Д.Гомбожав, УБ, УХХЭХ, 1964	тодорхойгүй
17	Яновский Ю “Морьтон” роман	Ч.Лхагваа, 1972, УБ, УХГ	орос хэлнээс

Украины уран зохиолоос монгол хэлнээ орчуулагдсан бүтээлүүдийн сэдэв нь Дэлхийн I, II дайн, дайны үеийн тагнуулын бодлого, ажил хөдөлмөр, баатарлаг үйлс зэрэг байна.

### 6. Чехийн уран зохиол Монголд

Чехийн уран зохиолоос хамгийн анх 1951 онд Б.Ринчен Ю.Фучикийн “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл” номыг орчуулсан байна. Чехийн уран зохиолыг монголчууд орос, чех, герман хэлнээс орчуулсан бөгөөд чех хэлнээс орчуулж байсан орчуулагч нар нь Б.Ринчен, Д.Алтангэрэл, Г.Дашдаваа, Б.Энэбиш, П.Нямаа нар болно. Б.Ринчен Алойс Йираасекийн “Эртний чех домог тууж”-ийг 1965 онд, “Чехийн эртний домог II”-ийг 1968 онд тус тус орчуулан хэвлүүлсэн.

Д.Алтангэрэл чех, словак хэлнээс Юлиус Фучикийн “Коммунизмын тугийн дор”, Марије Пуймановагийн “Амьдрал”, Иржи Марекийн “Уулзахын ерөөл”, Вацлав Ржезачийн “Долоон танк”, Ян Дрдагийн “Байлдагч Станда”, Марије Маеровагийн “Хотын захын хориглолт”, Людвик Ашкеназийн “Сонгино”, Франтишек Куфкагийн Цэцгийн багц”, Петр Йилемницкийн “Тэнгэрийн элч”, Рудольф Калчикийн “Ганцаардал”, Владимир Миначийн “Шийдэхийн өмнөхөн” зэрэг өгүүллэгүүдийг Д.Бадарчийн хамт орчуулан “Тэнгэрийн элч” (УБ, 1970) гэсэн нэрээр гаргав. Чехийн зохиолч Ян Отченашекийн “Ромео, Жульетта хоёр харанхуйд” буюу “Romeo, Julie a tma” (1958) бүтээлийг 1975 онд, Козакийн “Михал дарга” зохиолыг 1981 онд, Карел Чапекийн “Тожмой луутай тулалдсан нь” 1988 онд Д.Алтангэрэл орчуулан Улаанбаатар хотноо хэвлэсэн байна.

Г.Дашдаваа Пуйманова Мариегийн “Галаар наадвал” роман (УБ, 1974), Божена Немцовагийн “Эмээ” (УБ, 1987) романыг чех хэлнээс орчуулж, нийтийн хүртээл болгожээ. Витезслав Незвалын “Энх тайвны дуу” яруу найргийн түүвэр (орч. Х. Пэрлээ, УБ, 1954), Дрда Яны “Өгүүллэгүүд” (УБ, 1952), Марек Иржигийн “Манайд үүр гийлээ (УБ, 1955), “Алтан үст охин”, чех ардын үлгэрүүд, (УБ, 1956), Ян Амос Коменский (УБ, 1958), Ярослав Хашекийн “Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал” (УБ, 1965, 2009), Юлиус Фучикийн “Холбоочны гурван үсэг”(УБ, 1966), Ян Ленчогийн “Дурсамж” (УБ, 1989), Карла (УБ, 1956) Карел Чапекийн “Илд бамбай” (1993), Франц Кафкагийн “Шүүх ажиллагаа” (УБ, 2009) зэрэг бүтээлүүдийг монгол хэлнээ хөрвүүлжээ. Чехийн уран зохиолоос Монголд алдаршсан нь орчуулагч Ш.Очирбатын орос хэлнээс орчуулсан Ярослав Хашекийн “Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал” болно. 1951-1960 онд 20, 1961-1970 онд 5, 1971-1980 онд 4, 1981-1990 онд 28, 1991-2000 онд 9 бүтээл орчуулагдаж нийтийн хүртээл болжээ. 2010 онд МУИС-ийн чех судлалын төгсөгчид багшийн хамтаар “Чехийн шилдэг үлгэрүүд” номыг орчуулж нийтийн хүртээл болгожээ.

№	Зохиол, зохиогч	Орчуулагч, хэвлэлийн газар, хэвлэсэн он	Аль хэлнээс монгол хэлэнд орчуулсан
1	Адам Иржи. Марианы Лазнид байгаа Улаанбаатарын оюутнууд, найруулал	Залуучуудын үнэн, 1957, 4-р сарын 6	тодорхойгүй
2	Алоис Й. “Эртний чех домог тууж”	Б.Ринчен, УБ, УХХЭХ, 1965	чех хэлнээс
3	Алоис Й. “Чехийн эртний домог”	Б.Ринчен, УБ, УХХЭХ, 1968	чех хэлнээс
4	Алтан үст охин”, чех ардын үлгэрүүд	У.Лийгаа, УБ, 1956	тодорхойгүй
5	Алин Лайчиах. “Ильичийн байранд” шүлэг	Б.Жамц, Соёл утга зохиол, 1960 4-р сарын 21	тодорхойгүй
6	Буриан Э. Ф. Шинэ жилээр болсон явдал: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
7	Вайсс Я. Цуутай нохой: өгүүллэг	Б.Энэбиш //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
8	Гаек Иржи “Төвийг сахьсан нутаг”	Д.Алтангэрэл, УБ, 1983	чех хэлнээс
9	Гашек Я. “Нэргүй захидал”, өгүүллэг	Д.Даш, “Туяа”, 1958 №1 18-р талд	орос хэлнээс
10	Гашек Я. Барон Клейнгамплийн аж ахуйн өөрчлөлт, өгүүллэг	Г.Амар “Матар”, 1959 №11, 8-р талд	орос хэлнээс
11	Гора И. “Улаан талбайд” шүлэг	Г.Дамдин, Соёл, 1957 №3, 12-р талд	орос хэлнээс
12	Дрда Я. “Өгүүллэгүүд”	Хэн орчуулсан нь тодорхойгүй. УБ, 1952	тодорхойгүй
13	Дрда Я. Гурав дахь фронт: өгүүллэг	Б.Энэбиш, //Учрал, УБ,	чех хэлнээс

		УХГ, 1987	
14	Запотоцкий А. “Барунка” өгүүллэг	Б.Энэбиш //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
15	Илемницкий П. “Салхи эргэлээ”	Г.Дашдаваа, УБ, 1979	чех хэлнээс
16	Кайнер И. “Чехийн эрмэлзэл”	М.Цэрэндорж, Утга зохиол, 1957 4-р сарын 5	орос хэлнээс
17	Козак Я. “Михал дарга”	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1981	чех хэлнээс
18	Кальчик Р. Мариенка, өгүүллэг	орч. Б.Энэбиш, //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
19	Кожик Ф. Ажилчин: өгүүллэг, орч.	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
20	Козак Я. Алдарт ой: өгүүллэг, орч.	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
21	Кубка Ф. Хөгжмийн уянга	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
22	Ленчо Я. “Дурсамж”	П.Нямаа, УБ, 1989	чех хэлнээс
23	Маерова Марие “Хөгжөөнт үлгэрийн цоморлиг”	Хэн орчуулсан нь тодорхойгүй, УБ, АБЯ, 1979	тодорхойгүй
24	Марек Иржи “Манайд үүр гийлээ	Ц.Дүгэрсүрэн, УБ, 1955	тодорхойгүй
25	Марек Иржи. “Нэгэн эхийн яриа” өгүүллэг	Д.Намдаг, Цог, 1960 №6 40-46 талд	герман хэлнээс
26	Майерова М. Улаан туг: өгүүллэг	Б.Энэбиш, //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
27	Мориц Ю. Ягаан муурын нууц, 61 шүлэг,	олон орчуулагчтай. УБ, 1991	тодорхойгүй
28	Незвал В. “Энх тайвны дуу”	Х.Пэрлээ, УБ, 1954	тодорхойгүй



29	Незвал В. “Хамгийн сайхан үнэр, гэвэл...” шүлэг	Соёл утга зохиол, 1959, 10-р сарын 15	тодорхойгүй
30	Немцова Б. “Эмээ”, роман	Г.Дашдаваа, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
31	Новый К. 1945 оны майн нэгэн, өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
32	Отченашек.Я “Ромео Жульетта хоёр харанхуйд”	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1975	чех хэлнээс
33	Ольбрахт И. Оросын пролетарийн хувьсгалд талархдаг минь: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
34	Отченашек Я. Бухал өвсний яриа: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
35	Пуйманова М. “Галаар наадвал” роман	Г.Дашдаваа, УБ, 1974	чех хэлнээс
36	Пуйманова М. Учрал: өгүүллэг	Б.Энэбиш //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
37	Плухарж З. Бороонд бүүвэйлэгдсэн нь: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
38	Ржиха Б. Азарган тахиа: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
39	Руми И. “Хүү нь болох төвөгтэй” өгүүллэг	Д.Гомбодорж, Сүхбаатарын зам, 1960, 5-р сарын 1	орос хэлнээс
40	Сватоплук Г. Готвальдад бичсэн захидал: өгүүллэг,	орч. Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
41	Секера Й. Партизаны элч: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
42	Стрнадель И. Цонхны доор цуурайтна: өгүүллэг	орч. Д.Алтангэрэл //Учрал, УБ, УХГ, 1987	чех хэлнээс
43	Сургуультай нохой, Чех ардын үлгэр	Д.Содномдаржаа, 1957	орос хэлнээс
44	Томан Й. Замын эхэн:	Д.Алтангэрэл //Учрал,	чех хэлнээс

	өгүүллэг	Уб, УХГ, 1987	
45	Тэнгэрийн элч, чех, словакийн зохиолчдын өгүүллэг	Д.Алтангэрэл, УБ, 1970	чех, словак хэлнээс
46	Флариан М. Улаан цэрэг Рудо армейци, шүлэг	Б.Ринчен, “Утга зохиол, 1957, 7-р сарын 28	чех хэлнээс
47	Франц Кафка, Шүүх ажиллагаа	Ц.Сүхбаатар, Дэлхийн сонгодог зохиол, 19-р боть, Монсудар, УБ, 2009	орос хэлнээс
48	Фрид Н. Хавх: өгүүллэг	Д.Алтангэрэл //Учрал, Уб, УХГ, 1987	чех хэлнээс
49	Фучик Ю. Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл	Б.Ринчен, УБ, 1951	чех хэлнээс
50	Фучик Ю. “Холбоочны гурван үсэг”	орч. Д.Хишигжаргал, УБ, 1966	тодорхойгүй
51	Фучик Ю. Мөнх орших үйлс	А.Самбалхүндэв, Соёл утга зохиол, 1960, 4-р сарын 21	тодорхойгүй
52	Фучик Ю. Бодит өгүүллэг	Б.Энэбиш//Учрал, Уб, УХГ, 1987	чех хэлнээс
53	Хашек Я.Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал	Ш.Очирбат, УБ, УХГ, 1965, Дэлхийн сонгодог утга зохиолын чуулган, 36-р боть, УБ, Монсудар, 2009	орос хэлнээс
54	Хнеупек Б. Арслангийн одонт генерал: сурвалжлага, найруулал	орч. Б.Дашцэрэн, 1987	тодорхойгүй
55	Чапек К. “Тожмой луутай тулалдсан нь”	Д.Алтангэрэл, УБ, УХГ, 1988	чех хэлнээс
56	Чапек К. Хүний аминд халдсан нь: өгүүллэг, 1991	Д.Алтанхуяг //Алмас эрдэнийн хулгайч, Илд бамбай ХГ, УБ,	тодорхойгүй
57	Чапек К. Жүжигчин алга	орч. Ц.Барадий //Илд	тодорхойгүй

	болсон нь: өгүүллэг	бамбай, 1992	
58	Чапек К. Ноён Гиршийн сураг тасарсан нь: өгүүллэг	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
59	Чапек К. Оплатагийн мөхөл: өгүүллэг	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
60	Чапек К. Профессор Роусын туршилт: хошин детектив	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
61	Чапек К. Тасалбар: өгүүллэг	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
62	Чапек К. Шуудан дээр гарсан гэмт хэрэг: өгүүллэг	Ц.Барадий //Илд бамбай, 1992	тодорхойгүй
63	Чапек К. Яруу найрагч: өгүүллэг	Д.Алтанхуяг //Алмас эрдэнийн хулгайч, Илд бамбай ХГ, УБ, 1991	тодорхойгүй
64	Шайнер Д. Магтаал дуутай адил буюу: өгүүллэг, орч.	Д.Алтангэрэл //Учрал, Уб, УХГ, 1987	чех хэлнээс
65	Чехийн шилдэг үлгэрүүд	Д.Энхжаргал болон бусад, 2010	чех хэлнээс
66	Эрдэмтэй нохой, Чех ардын үлгэр, “Унших бичиг”	Бага сургуулийн 4-р ангид үзнэ. 1959	тодорхойгүй
67	Ян Амос Коменский	Тодорхойгүй. УБ, 1958	тодорхойгүй

Монгол хэлнээ орчуулагдсан чехийн уран зохиолын сэдэв нь түүх домог, дэлхийн I, II дайн, шүүх, гэмт хэрэг, хууль, хувьсгал, хайр сэтгэл, байгаль дэлхий, чехийн ёс заншил, хөдөөгийн амьдрал гэх зэрэг байна.

### Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд Украин, Белорусс, Болгар, Чех, Словак, Польш зэрэг зургаан улсын уран зохиол Монголд орчуулагдаж, нийтийн хүртээл болсон тухай өгүүлж байна. Эдгээр улсын уран зохиолын орчуулга дараах онцлогийг агуулж байна.

- Бидэнд буй судалгааны материалаас үзэхэд, Украин болон Белоруссын уран зохиолыг орос хэлнээс орчуулсан байна. Оросоос бусад слав хэлтэн

- улсуудын уран зохиолыг монголчууд болгар, орос, герман, словак, чех, польш, эсперанто, солонгос хэлнээс монгол хэлэнд хөрвүүлжээ. Монголчууд Оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиолоос 500 орчим бүтээлийг орчуулан, хэвлэсэн байна.
- Нийт бүтээлүүдийг ямар хэлнээс орчуулсныг мэдэх боломжгүй байна. Учир нь зарим бүтээлүүдэд аль хэлнээс орчуулсныг заагаагүй байна. Монгол улсын төв номын сан, Нацагдоржийн нэрэмжит Нийтийн номын сан, МУИС-ийн номын сангуудад байгаа бүтээлүүдийн зарим нь аль хэлнээс орчуулагдсан нь тодорхойгүй, тэр бүү хэл урагдаж хуучирсан, орчуулагчийн талаарх мэдээлэл байхгүй зэрэг нь судалгаанд хүндрэл учруулж байна.
  - Украин, Белорусс, Болгар, Чех, Словак, Польш зэрэг 6 улсын уран зохиолоос монголчууд орчуулахдаа ихэнхийг нь орос хэлнээс орчуулсан байна.
  - Орчуулагдсан бүтээлийн тооны хувьд хамгийн олон бүтээлийг Болгарын уран зохиолоос орчуулжээ. Зохиолын хэмжээгээр белорусс, болгар, чех, польш, украины уран зохиолоос нэлээд томоохон хэмжээтэй романууд орчуулагдсан нь ажиглагдаж байна.
  - Оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиолоос болгар, чех, польшийн уран зохиолыг тухайн эх хэлнээс нь орчуулж байсан байна. Польш, Чехийн уран зохиолыг польш, чех хэлнээс эрдэмтэн Б.Ринчен орчуулжээ.
  - Польшийн уран зохиолыг польш хэлнээс дагнан орчуулж байсан орчуулагч нь эрдэмтэн Б.Ринченгээс гадна Д.Ким байна. Словак, Чех, Украины уран зохиолыг словак, чех, орос хэлнээс Д.Алтангэрэл орчуулсан байна. Болгар хэлнээс монгол хэлэнд дагнан орчуулж байсан орчуулагчид нь А.Самбалхүндэв, Н.Лхагва, Г.Донид, Б.Жамъянбаатар нар байна. Белорусс, украин хэлнээс орчуулсан баримт олдсонгүй.
  - Монгол хэлнээ орчуулагдсан оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиолын нийтлэг сэдэв нь дэлхийн I,II дайны үеийн түүх, хувьсгал, эх орон үндэстний төлөө тэмцэл зэрэг байна.
  - Монгол хэлнээ орчуулагдсан оросоос бусад слав хэлтэн улсуудын уран зохиолоос хамгийн ихээр нийтэд түгэн дэлгэрч, нэрд гарсан бүтээлүүд нь Чехийн зохиолч Ю.Фучикийн “Цаазын газар сурвалжилсан тэмдэглэл”, Я.Хашекийн “Эрэлхэг цэрэг Швейкийн хөгтэй явдал”, Украины зохиолч Ю.Дольд Михайликийн “Ганц дайчин ганцаардахгүй” зэрэг бүтээлүүд болно.

### Номзүй

1. Гадаадын уран зохиолыг монгол хэлээр орчуулсан нь (1956-1960), Эмхтгэсэн Д.Бүрэндалай, УХХЭХ, 1963

2. Монгол улсад хэвлэгдсэн гадаадын уран зохиолын номзүйн бүртгэл (1985-2005), УБ, 2007
3. Шархүү А.Дагвадорж, Ч.Галбаяр, Г.Гүн-Үйлс, Дэлхийн уран зохиолын бага нэвтэрхий толь
4. Энхжаргал.Д (2010) Монголын уран зохиол Чехэд, Гадаад хэл соёл судлал, №333(14), 65-74
5. Энхжаргал.Д(2015) “Монгол хэлнээс чех хэлэнд, чех хэлнээс монгол хэлэнд орчуулагдсан бүтээлүүд”, Acta Mongolica, ISSN:20741014, vol.16 (426), 254-263 <http://ims-num.org/acta-mongolica> -сэтгүүл-боть15/ open access